



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЗАХИРАЛ  
Я.ПҮРЭВЖАВ ТАНАА**

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.18 № 02/16

**ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ**

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Эрчим хүчний хөгжлийн төвийн 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Эрчим хүчний газрыг татан буугдах үеэр 47,3 сая төгрөгийн үнэтэй 08-33 УБУ улсын дугаартай митцубиши пажеро, 33,4 сая төгрөгийн үнэтэй УБД 03-20 улсын дугаартай сузуки витара автомашиныг ТӨХ хураан авсан байна. Эрчим хүчний газрын хөрөнгийг Эрчим хүчний хөгжлийн төвд шилжүүлэх Төрийн өмчийн хорооны тогтоолд энэхүү 2 автомашиныг оруулан шийдвэрлэсэн боловч Төрийн өмчийн хороо хураан авсан 2 автомашиныг Эрчим хүчний хөгжлийн төвд хүлээлгэн өгөөгүй бөгөөд Эрчим хүчний хөгжлийн төвийн 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасныг үндэслэн Төрийн өмчийн хороогоор 2 автомашины асуудлыг шийдвэрлүүлэн зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2013 оны 7 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус төвийн СЭЗХ-ийн дарга Д.Бямбасүрэн, Ерөнхий нягтлан бодогч Л.Балган нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:**

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР**

Л.ОДГЭРЭЛ

**АЛТАН ЖОЛОО АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ**

П.РЭНЦЭНМЯДАГ


**ЗӨВШӨӨРСӨН:**

**ЭХХТ-ЫН СЭЗХ-ИЙН ДАРГА**

**ЭХХТ-ЫН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ**

Д.БЯМБАСҮРЭН

Л.БАЛГАН



070046